

БАТЛАВ
АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ийн
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ *М.Мөнхөө*



БАТЛАВ
ХЭЛТ ЭНД СЭФТИ СОЛУШИНС ХХК-ийн
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ *Д.Нарансүх*



СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ГЭРЭЭ.

2023 оны 06 -р сарын 22 өдөр

дугаар №.. 2023/56

Улаанбаатар хот

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ.

Нэг талаас “Амгалан дулааны станц” Төрийн өмчит хувьцаат компани /цаашид “Захиалагч” гэх/-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал М.Мөнхөө нөгөө талаас Хэлт энд сэфти солушинс ХХК-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал Д.Нарансүх /цаашид “Гүйцэтгэгч” гэх/ нар Монгол Улсын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 17 дугаар зүйл, 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тус тус үндэслэн дараах зүйлүүдийг харилцан тохиролцож энэхүү гэрээг (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

Нэг. Гэрээний нийтлэг үндэслэл

- 1.1 Гүйцэтгэгч нь захиалагчийн даалгаврын дагуу Амгалан дулааны станц ТӨХК-ийн ажилтан албан хаагчдын ажлын байранд “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28.1.5”-д заасан Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлд суурилсан хөдөлмөрийн эрүүл мэндийн сургалт зохион байгуулахтай холбоотой ажлыг гэрээний салшгүй хэсэг болох хавсралтад заасан нэр төрлийн дагуу энэхүү гэрээгээр зохицуулна.
- 1.2 Гүйцэтгэгч тал нь сургалтын агуулгын хэрэгцээг тодорхойлох хөдөлмөрийн нөхцөлийн түргэвчилсэн үнэлгээг MNS ISO/IEC 17020 итгэмжлэлтэй эрүүл ахуйн техникийн хяналтын албаараа гүйцэтгүүлнэ.
- 1.3 Талууд гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулснаас хойш нэг сарын хугацаанд сургалтыг зохион байгуулж эхэлсэн байна.

Хоёр. Гэрээний хугацаа

- 2.1 Гэрээний урьдчилгаа төлбөр Гүйцэтгэгч талын дансанд шилжснээр нь талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тамга тэмдэг даран баталгаажуулсанаар хүчин төгөлдөр болж, Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсний дараа талууд гэрээ дүгнэсэн актад гарын үсэг зурсанаар дуусгавар болно.
- 2.2 Гүйцэтгэгч нь энэхүү гэрээний хавсралтад заасан ажлуудыг гэрээнд гарын үсэг зурагдсан өдрөөс эхлэн 2023 оны 10 дугаар сарын 31-ийг хүртэлх хугацаанд хэрэгжүүлнэ.

Гурав. Үнэ төлбөрийн нөхцөл

- 3.1 Энэ гэрээний нийт үнэ 15,180,000 /Арван таван сая нэг зуун наян мянга /-н төгрөг бөгөөд үнийн дүнд НӨАТ шингэсэн байна.
- 3.2 Захиалагчаас гүйцэтгэгчид урьдчилгаа төлбөр болох гэрээний үнийн дүнгийн 40% буюу 6,072,000 (зургаан сая далан хоёр мянга)-н төгрөгийг гэрээ байгуулснаас хойш 14 хоногийн дотор шилжүүлнэ.
- 3.3 Үлдэгдэл төлбөр болох 9,108,000 (есөн сая нэг зуун найман мянга)-н төгрөгийг гэрээт ажлыг гүйцэтгэж дууссаны дараа гэрээ дүгнэсэн актыг үндэслэн 14 хоногийн дотор

Захиалагч:

M. Mönkhö

1/3

Гүйцэтгэгч:

D. Naransukh

төлбөрийг нэхэмжлэлийн дагуу гүйцэтгэгчийн Хаан банк 5115 119 772 тоот дансанд шилжүүлнэ.

Дөрөв. Талуудын хүлээх хариуцлага

- 4.1 Гүйцэтгэгч нь гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, товлосон хугацаандаа сургалт зохион байгуулаагүй тохиолдолд нийт үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг захиалагчид хоног тутам төлөх ба нийт алдангийн үнийн дүн гэрээний нийт үнийн дүнгийн 10% -иас хэтрэхгүй байна.
- 4.2 Захиалагч нь сургалтын чанар, ажлын байрны шаардлагад тохирч байгаа эсэхийг шалган үзээд хүлээн авсаны дараа гэрээнд заасан хугацаанд тооцоо хийх, төлбөрийн хугацааг хожимдуулбал хожимдсон хоног тутамд хүлээгдэж байгаа төлбөрийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг нийлүүлэгчид төлөх ба алдангийн дүн нь гэрээний хүлээгдэж байгаа төлбөрийн үнийн дүнгийн 10% хувиас хэтрэхгүй байна.
- 4.3 Захиалагчийг төлөөлж гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлыг Амгалан дулааны станц ТӨХК-ийн хангамжийн мэргэжилтэн М.Моломжав хариуцан ажиллана. Утас-99122684
- 4.4 Гүйцэтгэгчийг төлөөлж гэрээтэй холбоотой асуудлыг Хэлт энд сэфти солушинс ХХК-ийн Гүйцэтгэх захирал Д.Нарансүх хариуцан ажиллана. Утас:94004884

Тав. Талуудын эрх үүрэг

- 5.1. Гүйцэтгэгч нь захиалгчийн захиалсан сургалтыг гэрээний 6-р зүйлд заасны дагуу буюу хийж гүйцэтгэх үүрэгтэй.
- 5.2. Гүйцэтгэгч тал нь захиалагч талаас гэрээ дүгнсэн акт гаргаж баталгаажуулснаас хойш 14 хоногийн дотор гэрээний 3.3-д заасан үнийн дүнг нэхэмжлэх эрхтэй.
- 5.3. Захиалагч тал гүйцэтгэгийн гүйцэтгэсэн ажлыг хүлээн аван гэрээ дүгнсэн акт гарж баталгаажсаны хойш 14 хоногийн дотор гэрээний 3.3-д заасан үнийн дүнг нэхэмжлэхийн дагуу гэрээний 3.3-д заасан дансанд шилжүүлэх үүрэгтэй.

Зургаа. Сургалтын хөтөлбөрийн чанар, стандарт

- 6.1 Гүйцэтгэгчийн зохион байгуулах сургалтын сэдэв нь ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн онцлогт нийцсэн байна.
- 6.2 Талууд энэ гэрээний дагуу хүлээн авсан мэдээ, мэдээлэл баримт бичгийн нууцлалыг чанд нууцлан хадгална.

Долоо. Давагдашгүй хүчин зүйл

- 7.1 Гэрээг хэрэгжүүлэх явцад улс төрийн хориг, байгалийн гамшиг, хорио цээр тогтоох, цэргийн үймээн, төрийн эргэлт, ажил хаялт болон бусад нөхцлүүд бий болсноос үүдэж гэрээний нөхцлүүд хэсэгчилэн болон бүрэн биелээгүй тохиолдолд хоёр талын аль нь ч хариуцлага хүлээхгүй.
- 7.2 Давагдашгүй хүчин зүйлийн нөхцөлүүд гарч эхэлсэн тохиолдолд гэрээний хугацаа дуусахаас өмнө талууд бие биедээ бичгээр мэдээлж цаашид хэрхэн ажиллах талаар зөвшилцөнө.

Найм. Гэрээг цуцлах үндэслэл

- 8.1 Гүйцэтгэгч энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа буюу ноцтой зөрчсөнөөс бусад тохиолдолд Захиалагч энэхүү гэрээний үйлчлэлийг дуусахаас өмнө тасалдуулахгүй.

Захиалагч:



2/3

Гүйцэтгэгч:



Ес. Бусад нөхцөл

- 9.1 Талуудын аль нэг нь нөгөөдөө гэрээтэй холбогдох мэдээлэл солилцох тохиолдолд мэдээллийг авсан тал хуанлийн 7 хоногт багтаан нөгөө талдаа тавьсан асуудлаар тодорхой хариу өгнө.
- 9.2 Талууд аль нэгнийхээ зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээг гурав дахь талд шилжүүлэхийг хориглоно.
- 9.3 Гэрээг монгол хэл дээр 3 хувь үйлдэж, Захиалагч 2 хувийг Нийлүүлэгч 1 хувийг авах бөгөөд хувиуд ижил тэгш хүчинтэй.
- 9.4 Гэрээг хоёр тал зөвшөөрсөн тохиолдолд 1 удаа сунгаж болно.
- 9.5 Гэрээнд хоёр тал гарын үсэг зурсан өдрөөс хүчин төгөлдөр байна.
- 9.6 Гэрээнд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр үйлдсэн гэрээний хэлбэрээр нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд нэмж засварласан эх хувьд баллаж засварласан буюу гараар нэмж бичсэн болон бусад энгийн аргаар хийсэн оруулга засвар нэмэлт бичилтийг хүчинтэйд тооцохгүй.
- 9.7 Энэхүү гэрээнд шууд заагаагүй бусад аливаа асуудлыг Монгол улсын хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД
ЕРӨНХИЙ НИЯГТЛАН БОДОГЧ:

 Ө.УДВАЛ

АЖ АХУЙ, ХАНГАМЖИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА:

 Г.БАТТУЛГА

ХЯНАЛТЫН ХЭЛТЭСИЙН
ДАРГА:

 Ц.МАНДАХСАЙХАН

ХУУЛИЙН
МЭРГЭЖИЛТЭН:

Г.САРУУЛ

СУРГАЛТ СУДАЛГААНЫ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН:

Н.ПАГМАА

ГЭРЭЭ БОЛОВСРУУЛСАН
ХАНГАМЖИЙН МЭРГЭЖИЛТЭН:

М.МОЛОМЖАВ

Хаяг: Монгол улс, Улаанбаатар
хот, Баянзүрх дүүрэг, 8-р хороо, УС-15-1-1
Утасны дугаар: 77111251
РД: 6021646

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ХЭЛТ ЭНД СЭФТИ СОЛУШИНС ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ:

Д.НАРАНСҮХ



Хаяг: УБ хот БЗ дүүрэг 25-р хороо УБ Тауэр барилга
705 тоот
Утасны дугаар: 75779922
РД: 5774705

Захиалагч:



3/3

Гүйцэтгэгч:

